

БАТЛАВ.

И.БАТХҮҮ

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж  
Хуулийн мэргэжилтэн  
(дотоод, 12 хүн/сар, үргэлжилсэн)

## 1. Ажлын байрны зорилго, зорилт

Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад L3936-MON: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг (ЭЗХАБ) хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлэгч байгууллага нь Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), гүйцэтгэгч агентлаг нь Барилга, хот байгуулалтын яам болон Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба юм. Төслийн хүрээнд мэдээллийн технологийн шийдэлд суурилсан “Замын-Үүд” чөлөөт бүсийн боомтын нэвтрэх системийг байгуулах зорилготой юм.

Энэхүү зорилгын хүрээнд улсын хэмжээний Хилийн нэгдсэн менежментийн (ХНМ) системийг бий болгож хэрэгжүүлэх явдал юм. Энэ системийн нэгдсэн санд нэвтрэхэд өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хувь хүний нууц, хөрш улсууд болон олон улсын чөлөөт бүсийн хууль эрх зүйн орчныг илүү сайжруулах хэрэгтэй юм.

## 2. Зорилго

Төслийн хүрээнд Хилийн нэгдсэн удирдлагын системийн өгөгдлийн санг хамгаалах чиглэлээр мэргэшсэн хуулийн зөвлөхийг авч ажиллуулах юм. Зөвлөх нь хэрэгжүүлэгч байгууллага болох Эдийн засаг хөгжлийн яаманд (ЭЗХЯ)-д ажлаа шууд тайлагнах бөгөөд гүйцэтгэгч байгууллагуудтай, тухайлбал Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ), Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ), Гаалийн ерөнхий газар (ГЕГ) болон Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба (ЗҮЧБЗАА), Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-тэй нягт хамтран ажиллана.

Хуулийн мэргэжилтэн нь Монгол Улсын хууль эрх зүйн тогтолцооны талаар өндөр туршлагатай, ялангуяа хууль тогтоох үйл явц, бодлого, орон нутгийн зохицуулалтын орчны талаар нарийвчилсан ойлголттой байх болно. Хуулийн төсөл боловсруулах, бодлого, хууль тогтоомж боловсруулах чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг үүрэг даалгавартай холбоотой 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна. Зөвлөх нь англи хэлийг сайн эзэмшсэн байх ба англи хэл дээр илтгэл бичих чадвартай. Хөгжлийн агентлагаас санхүүжүүлдэг төсөл, хөтөлбөрүүдэд холбогдох туршлагатай байх шаардлагатай. Хөгжлийн агентлагаас санхүүжүүлдэг төсөл, хөтөлбөрүүдэд холбогдох туршлагатай байх шаардлагатай.

Зөвлөх нь Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллага зэрэг гэрээлэгч тал болох Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын чөлөөт худалдааны хэлэлцээртэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор худалдаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулахад гүйцэтгэгч байгууллага болон холбогдох яамдад зөвлөх үйлчилгээ үзүүлнэ. гишүүн болон одоо хэлэлцээ хийж байгаа, мөн БНХАУ-тай эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хоёр талт гэрээ; олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн “Монгол

Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хилийн нэгдсэн мэдээллийн сангийн журам"-ыг боловсруулан гаргана.

### 3. Гүйцэтгэх үндсэн үүрэг, хүлээгдэж буй үр дүн

Зөвлөх нь олон улсын тэргүүн туршлага, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хил хамгаалал түүнд хамаарах хууль болон хуулийн нэмэлт, өөрчлөлт, түүнчлэн холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг судалж, судалгааны дүнд үндэслэн хийлийн нэгдсэн мэдээллийн системийн аюулгүй байдал, өгөгдлийн нууцыг хамгаалах талаар хууль эрх зүйн үндэслэл, үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гаргах бөгөөд дээр дурдсан журмыг боловсруулах саналыг бэлтгэнэ. Нарийвчилсан үүрэг даалгаварт дараах зүйлс орох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- i) Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам болон бусад холбогдох хууль, тогтоомжийг судалж, өгөгдлийн аюулгүй байдлын мэдээллийг цуглуулж, эрх зүйн үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;
- ii) Хөрш улсууд болон олон улсын чөлөөт бүсийн хууль эрх зүйн орчин, чиг хандлагыг хөгжүүлэх, татварын болон татварын бус хөнгөлөлт, чөлөөлөлт, худалдааг хөнгөвчлөх, дэмжих бодлого, менежментийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх
- iii) Монгол Улсын нөхцөл байдалд тохирохуйц чөлөөт бүсийн талаар олон улсын хууль эрх зүй, шилдэг туршлагын харьцуулсан судалгаа хийж, өгөгдөл мэдээллийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох журмыг боловсруулах
- iv) Олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжийн дагуу хилийн мэргэжлийн байгууллагууд зорчигч, бараа тээврийн мэдээлэл солилцох ажлыг хэрхэн зохион байгуулдаг талаар олон улсын туршлагыг нэвтрүүлэх, олон улсын хууль тогтоомжийн дагуу эдгээрт хамаарах өгөгдлийн нууцлалын талаарх мэдээллийн аюулгүй байдлын бодлого, стандартын хүрээнд зөвлөмж боловсруулах
- v) Хил, хяналтын байгууллага хооронд өгөгдөл солилцохтой холбогдуулан зарим хууль, эрхзүйн орчныг шинэчлэхтэй холбоотой зөвлөмж боловсруулах
- vi) Эдийн засаг, хөгжлийн яаманд зөвлөмж боловсруулан хүргүүлэх шаардлагатай бол эрх зүйн баримт бичгийг сайжруулахад туслалцаа үзүүлэх
- vii) Төслийн захирал болон зохицуулагчаар дамжуулан төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагуудын өгсөн бусад үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх

### 4. Тавигдах шаардлага:

- Хууль, эрх зүйн чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, мэдээллийн системийн чиглэлээр мэргэшиж ажилласан бол давуу тал болно.
- Ур чадварын хувьд хуулийн зөвлөх чиглэлээр сайн мэдлэг, туршлагатай, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан хуулийн төсөл, журам боловсруулж байсан туршлагатай, энэ чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Багаар ажиллах, зохион байгуулах ур чадвартай, техникийн баримт бичгийн сайн төсөл боловсруулах чадвартай байх
- Англи хэлний чөлөөтэй ярих бичих чадвартай байх, хятад хэлтэй бол давуу тал болно.

Ерөнхий туршлага, хамгийн багадаа: 8 жил

Мэргэшсэн туршлага (даалгавартай холбоотой): 5-8 жил

<b>Томилолтын байршил:</b>	<b>Календарийн хоног:</b>		<b>Хугацаа:</b>
<b>Улаанбаатар хотод:</b>			
УБ оффис			
<b>Дорноговь аймагт:</b>			
Замын-Үүд сум			
<b>Нийт:</b>			264 хоног /12 хүн/сар

Гэрээний төрөл: бүтээгдэхүүн нийлүүлэх, үргэлжилсэн

**Үр дүн, бүтээгдэхүүн нийлүүлэх:**

- Ажлын төлөвлөгөө (батлуулах)
- Сар бүрийн гүйцэтгэлийн тайлан
- Зөвлөмж боловсруулах, журмын төсөл
- 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдөр, ажлын явцын тайлан 1 - Монгол Улсын чөлөөт бүсийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам болон бусад холбогдох хууль, тогтоомжийг судалж, өгөгдлийн аюулгүй байдлын мэдээллийг цуглуулж, эрх зүйн үнэлгээ.
- 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр, ажлын явцын тайлан 2 - Хөрш улсууд болон олон улсын чөлөөт бүсийн хууль эрх зүйн орчин, чиг хандлагыг хөгжүүлэх, татварын болон татварын бус хөнгөлөлт, чөлөөлөлт, худалдааг хөнгөвчлөх, дэмжих бодлого, менежментийн үйл ажиллагааны үнэлгээ.
- 2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр, ажлын явцын тайлан 3 - Олон улсын шилдэг туршлага, стандартын эмхэтгэлийг Монгол Улсад нэвтрүүлэх, тэдгээрийг Монгол улсын нөхцөлд хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах.
- 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдөр, эцсийн тайлан 4 - Монгол Улсын нөхцөл байдалд тохирохуйц чөлөөт бүсийн талаар олон улсын хууль эрх зүй, шилдэг туршлагын харьцуулсан судалгаа хийж, өгөгдөл мэдээллийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох журмын эцэслэгдсэн төсөл.